

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр, Лхагва гараг*

***Хуралдааны тэмдэглэлийн агуулга***

<b><i>Хуралдааны товч тэмдэглэл:</i></b>	1-2
<b><i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i></b>	3-4

---

<i>1. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	3
<i>2. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	3-4



Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**П.Анужин:** Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 05 минут үргэлжилж, ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 29 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
НИЙГМИЙН БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА



Эм, эмнэлгийн хэрэгслийн шинэчилсэн найруулгын төслийг баталсантай холбогдуулан Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлнэ. Та бүхэнд тогтоолын төслийг танилцуулсан байгаа.

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний Улсын Их Хурлын тогтоолтой холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Тийм.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т заасны дагуу хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг гаргаж байна. Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Чинбүрэн гишүүн санал хэлэх юм уу? Санал хураалт гишүүдээ, баярлалаа. Тогтоолын төсөл 60 хувиар дэмжигдлээ. Анхны хэлэлцүүлгийг, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн

Жигжидсүрэнгийн Чинбүрэнг томилж байна.

11.27 цаг

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөж байна. Хуралдаа идэвхтэй оролцсон эрхэм гишүүд та бүхэндээ баярлалаа.

Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд бол үргэлж мэргэжлийн, манай, танай гэхгүй, сөрөг хүчин эрх барьж байгаа намтайгаа хамтарч, асуудлын төлөө бол үргэлж нэг цул байж, үргэлж энэ батлагдсан Улсын Их Хурал дээр хэлэлцэгдэж байгаа, Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэгдэж байгаа хуулиуд дээр үргэлж мэргэжлийн зүгээс хандаж, өндөр ирцтэй хуралдаандаа оролцож байсан гэдгийг бас онцлон тэмдэглэж хүсье. Энэ Байнгын хорооны бас байнгын ирц өндөртэй байдагт өөрийнхөө энэ хувь нэмрээ оруулсан, үргэлж мэргэжлийн талаас ханддаг Байнгын хорооны эрхэм гишүүддээ бас баярлаж талархсанаа илэрхийлье.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна. Гишүүддээ амжилт хүсье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

